



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017.03.15 № 3/443
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газрын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаархи мэдээлэл

Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газрын удирдлага нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.


Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем, тэгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газрын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, бодитой илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



1

ТӨР ЗАСГИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:**

Санхүүгийн Аудитын Газрын дарга
Тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 260512
Аудитын менежер: Я.Самбууням
Утас: 260512
Цахим хаяг: sambuunyamyaa@audit.gov.mn

Аудитор: Ж.Болормаа
Утас: 260512
Цахим хаяг: bolormaa@audit.gov.mn

Стандарт дүгнэлт Аудит ХХК
Утас: 70111721 Цахим
хаяг: sd_audit@yahoo.com

Үндэсний аудитын газар
Байршил: Чингэлтэй дүүрэг
Цахим хуудас: www.audit.mn

Аудитын тайлан

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Агуулга

2	Аудитын тайлан.....	4
2.1	Оршил.....	4
2.2	Аудит хийхүндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, аргазүй, шалгуур үзүүлэлт	5
2.4	Байгууллагын зорилго, үйлажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	7
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл.....	8
2.9.1	Нягтлан бодох бүртгэлийн бодлогыг баримт бичгийн талаар	8
2.9.2	Биет бус хөрөнгийн талаар	9
2.10	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	9
2.11	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	9
2.12	Шилэн дансны мэдээлэл	10
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	10
2.14	Саналдүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
3	Менежментийн захидал	13
3.1	Нягтлан бодох бүртгэлийн бодлогыг баримт бичгийн талаар	14
3.2	Үндсэн хөрөнгийн талаар.....	15
4	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	16
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	16
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	17
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	18
4.4	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	19

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газрын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитын дүн, дүгнэлтийг танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд энэ хуулийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8.9.1 дэх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газрын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Аудитыг төлөвлөлтийн шатанд боловсруулсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газрын 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн гаргасан төр, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Тус газрын удирдлагасанхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2017 оны 2 дүгээр сарын 25-наас 2017 оны 3 дугаар сарын 10-ны хооронд хийж, аудитын тайланг 2017 оны 3 дугаар сарын 15-нд эцэслэн

баталгаажуулж, үйлчлүүлэгчийн удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, хариуцаж хэрэгжүүлэв.

Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газар 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа 2017 оны 1 дүгээр сарын 24-нд Стандарт дүгнэлт аудит ХХК-д 118 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, аргазүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитыг төлөвлөх, гүйцэтгэх, тайлагнах үе шатны ажлыг гүйцэтгэж баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримталсан бодлого, стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

Аудитын үйл явц, үр дүнг Аудитын олон улсын стандартын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудит хийхэд Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, Санхүүгийн аудитын удирдамж – Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад тулгуурлав.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид Аудитын олон улсын стандартад зааснаар үйлчлүүлэгч байгууллагын үйл ажиллагаа, гадаад дотоод орчны талаар төлөвлөсөн бодлого, журмын дагуу шаардлагатай гэж үзсэн хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газрын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, ТАБ-СТА-Б-2.1 маягтаар баталгаажуулсан болно.

Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газрын удирдлага дараах хууль болон СТОУС, НББОУС, түүнд нийцүүлэн баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцэж байна.

Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газар санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд “энгийн” буюу мэдээллийн технологийн мэргэжилтэн аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзлээ.

Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газрын санхүүгийн тайлан, тодруулга, төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэх, ажил гүйлгээг бүртгэх, хянах үйл ажиллагаанд санхүүгийн “DIAMOND” програм хангамж ашиглажээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой уламжлалт болон хяналтын эрсдэлийг илрүүлэх, үнэлэх үе шатны ажлын талаар товч толилуулъя.

Аудитыг төлөвлөх үе шатанд байгууллага, түүний гадаад, дотоод орчны талаарх цуглуулсан мэдээлэл, ойлголтод үндэслэн эрсдэлийн үнэлгээний горим хэрэгжүүлэн 14 эрсдэлтэй асуудал тодорхойлон, тэдгээрийг ТАБ-СТА-Б-2.6 маягтад нэгтгэж, баримтжуулав.

Дээрх эрсдэлтэй асуудал тус бүрийг дахин нарийвчлан үнэлэхэд 5 асуудал эрсдэл өндөр, 4 асуудал эрсдэл дунд, 5 асуудал эрсдэл бага гэсэн үр дүн гарлаа.

Эрсдэлийн ерөнхий үнэлгээг ТАБ-СТА-Б-4.3 маягтад нэгтгэн баримтжуулсан бөгөөд нийт эрсдэлийн үнэлгээний түвшин 18 байна.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн эрсдэл өндөр буюу зайлшгүй шалгах эрсдэлтэй 5 асуудлыг аудитын чиглэл тус бүрээр нэгтгэж, тэдгээрийг сорих, шалгах аудитын горим сорил, шалгуур үзүүлэлт, нотлох зүйл цуглуулах арга замыг холбогдох маягтаар баримтжуулан баталгаажуулсан болно.

2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон
нь Төсвийн байгууллагын хувьд материаллаг байдлын суурийг төсвийн зардлаар тооцох нь оновчтой гэж үзсэнтэй холбоотой юм.

Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газрын 2016 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 4,759.9 сая төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 95.2 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 2 хувиар тооцсон нь өмнөх аудитаудаар зөрчилгүй санал дүгнэлт авч байсан, санхүү, бүртгэлийн ажилтнууд харьцангуй тогтвор сууришилтай ажиллаж байгаа бөгөөд эрсдэл бага гэж үнэлсэнтэй холбоотой юм.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх шатанд тогтоосон эрсдэлтүс бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, төлөвлөсөн ёсоор аудитын 4 чиглэлээр 5 эрсдэлтэй асуудалд 5 горим, сорил хэрэгжүүлж, түүний үр дүнг баримтжуулав. /ТАБ-СТА-В-3.1/

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэн тэдгээрийн гол үр дүн, нөхцөл байдлыг үнэлэхэд хэрэгжүүлсэн нийт горим сорилын 2 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-В-4.1/

Харин аудитыг төлөвлөх шатанд эрсдэлтэй гэж тооцсон боловч, аудитын горим сорил хэрэгжүүлэх явцад алдаа зөрчилгүй нь тогтоогдсон асуудлыг ТАБ-СТА-В-4.2 маягтаар нэгтгэж, баримтжуулав.

Санхүүгийн тайлан, тодруулга дах залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудалд дүн шинжилгээ хийж, алдаа зөрчлийг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа
зөрчилтэй асуудлын нэгтгэл

(Сая төгрөгөөр)

№	Буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг ангилсан байдал	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж болгосон асуудал	2	71.3	
2	Төлбөрийн акт тогтоосон			
3	Албан шаардлага өгсөн			
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн			
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн			
	Дүн	2	71.3	

Дээрх зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүй жагсаалтыг ТАБ-СТА-В-4.6.1-5 маягтад нэгтгэн баримтжуулав.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

Зөвлөмж болгохоор шийдвэрлэсэн буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 3 дугаар бүлгийн Менежементийн захидалд холбогдох зөвлөмжийн хамт оруулав.

2.9.1 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

Тус газар Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгээ шинээр мөрдөж байгаа зарим стандарт болон хууль эрхийн зарим актын өөрчлөлтийг тусгаж шинэчлэх шаардлагатай байна. Тухайлбал үндсэн хөрөнгөнд байгуулах элэгдэлийн хувь хэмжээг өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан шинэчлэн тогтоох, бараа материалыг зарлага болгох бодлого, аргачлал, цэвэр хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг бүртгэх бодлого зэргийг холбогдох стандартад нийцүүлэн шинэчлэх нь зүйтэй

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрийн байгууллагын онцлог, эрх зүйн орчинтой нийцүүлэн боловсруулж үйл ажиллагаандаа мөрдлөг болгосноор ажил гүйлгээг нягтлан бодох бүртгэлд стандартын дагуу үнэн зөв тусгах, үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны орлого, зарлагыг батлагдсан хэмжээнд холбогдох хууль тогтоомжийн дагуу зөв ангилж бүртгэх, тайлагнах, төсвийн өмнө хүлээсэн үүргийн биелэлтийг хангаж ажиллах зэрэг үйл ажиллагааг холбогдох хууль, тогтоомж, стандартын хүрээнд явуулах нөхцөл боломжийг бүрдүүлэх чухал ач холбогдолтой юм.

Шийдвэрлэсэн нь:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт оруулах зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

2.9.2 Биет бус хөрөнгийн талаар

Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газар 2016 оны санхүүгийн байдлын тайлан дах үндсэн хөрөнгийг биет болон биет бус хөрөнгө гэж ангилаагүй байна. Тухайлбал 71.3 сая төгрөгийн 6 төрлийн програм хангамжийг биет бус хөрөнгийн ангилалд оруулж тусд нь тайлагнах ёстой.

Энэ нь хөрөнгийг батлагдсан ангилалын дагуу үнэн ангилах батламж мэдэгдэлтэй зөрчилдөж байна.

Шийдвэрлэсэн:

Үндсэн хөрөнгийг батлагдсан ангилалаар үнэн зөв ангилах зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

2.10 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХ УЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газар Засгийн газрын ордоны байранд эрэгтэй, эмэгтэй үсчин, банк, эмийн сан, номын худалдаа зэрэг газруудад үйлчилгээний зориулалтаар түрээсийн гэрээ байгуулжээ.

Тус гэрээ байгуулах зөвшөөрөл, гэрээний нөхцлийн талаар холбогдох зөвшөөрөл шийдвэрийг холбогдох байгууллагаас албан ёсоор аваагүй байна.

Энэ нь Төрийн өмчийн хорооны 2012 оны 44 дүгээр тушаалаар баталсан Төрийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журмын 1.4-д "Төрийн өмчит хуулийн этгээд нь төрийн өмчийн эд хөрөнгийг бусад байгууллага иргэдэд ашиглуулах, түрээслүүлэхдээ Төрийн өмчийн хорооноос баталсан холбогдох журам зааврыг баримтлана" гэсэн заалтыг зөрчилдөж байна.

2.11 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар батлагдсан төсвийн гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулж, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газар өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан урсгал зардалд 3,034.8 сая төгрөгийн төсөв баталсан байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх мэдээллийг дор нэгтгэн харуулав.

Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн товчоо

/Сая төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
1	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	3,034.8	3,002.1	0.2	32.7
1.1	Урсгал зардал	3,034.8	3,002.1	0.2	32.7
1.2	Хөрөнгийн зардал				
1.3	Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл				
2	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	3,031.8	3,002.1	0.1	29.7
2.1	Улсын төсвөөс санхүүжих	2,889.4	2,889.4		
2.2	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих				
2.3	Төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос	142.5	112.7	0.1	29.8

Дээрх зардлуудын хэлбэлзэл нь төсвийн төлөвлөлтийг бодитой хийгээгүй, урсгал санхүүжилтийг бүрэн хийгээгүйтэй холбоотой байна.

2.12 Шилэн дансны мэдээлэл

Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газар Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1 зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

Энэхүү зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.14 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газар 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг Аудитын Олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газар 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажилгүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударгайлэрхийлсэн байна гэж үзэж “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

Аудитын явцад илэрсэн залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг менежментийн захидалд тусгасан бөгөөд эдгээр буруу илэрхийлэл буюу алдаа, зөрчлийн дүн материаллаг байдлын түвшингээс бага байгаа тул аудитын санал дүгнэлтийг хязгаарлах үндэслэлгүй байна.

Аудитын санал дүгнэлтийг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.



ТӨР ЗАСГИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал 1
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт
бичгийн талаар

Асуудал 2
Үндсэн хөрөнгийн талаар

3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналийн бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газрын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдолтойгоос нь эхлэн эрэмбэлэн үзүүлэв.

3.1 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

Илрүүлэлт

Тус газар Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгээ шинээр мөрдөж байгаа зарим стандарт болон хууль эрхийн зарим актын өөрчлөлтийг тусгаж шинэчлэх шаардлагатай байна. Тухайлбал үндсэн хөрөнгөнд байгуулах элэгдэлийн хувь хэмжээг өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан шинэчлэн тогтоох, бараа материалыг зарлага болгох бодлого, аргачлал, цэвэр хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг бүртгэх бодлого зэргийг холбогдох стандартад нийцүүлэн шинэчлэх нь зүйтэй

Зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрийн байгууллагын онцлог, шинээр мөрдөж байгаа стандарт, эрх зүйн орчинтой нийцүүлэн нэмэлт өөрчлөлт оруулан баталгаажуулах.

Эрсдэл

Үнэн зөв байдал - Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланд тусгасан ажил гүйлгээ, үлдэгдэл нь тооцооллын алдаагүй, зөв хураангуйлж бүртгэсэн болон түүнийг зохицуулж буй хууль тогтоомжуудтай нийцэж байх батламж мэдэгдэл зөрчигдөх

Төсвийн захирагчийн хариу

Зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлнэ

3.2 Үндсэн хөрөнгийн талаар

Илрүүлэлт

Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газар 2016 оны санхүүгийн байдлын тайлан дах үндсэн хөрөнгийг биет болон биет бус хөрөнгө гэж ангилаагүй байна.

Тухайлбал 71.3 сая төгрөгийн 6 төрлийн програм хангамжийг биет бус хөрөнгийн ангилалд оруулж тусад нь тайлагнах ёстой.

Энэ нь хөрөнгийг батлагдсан ангилалын дагуу үнэн ангилах батламж мэдэгдэлтэй зөрчилдөж байна.

Эрсдэл

Зөвлөмж

Үндсэн хөрөнгийг батлагдсан ангилалаар үнэн зөв ангилах зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв

Төсвийн захирагчийн хариу

Зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлнэ

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	397,587,267.48	888,699,677.13
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3,946,297.48	-
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	3,946,297.48	-
31110	Төгрөг		
31120	Гадаад валют		
31130	Нэмэлт санхүүжилт		
31140	Касс арилжааны банк		
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	-
3121	Төгрөг	-	-
31211	Төрийн сангийн харилцах		
31212	Монгол банкин дахь харилцах		
31213	Арилжааны банк дахь харилцах		
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах		
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах		
31216	Нэмэлт санхүүжилтийн арилжааны банк		
3122	Гадаад валют	-	-
31221	Төрийн сангийн харилцах		
31222	Монгол банк дахь харилцах		
31223	Арилжааны банк дахь харилцах		
31224	Бусад төсөл, нөөцийн харилцах		
31400	Замд яваа мөнгөн хөрөнгө		
31500	Хадгаламж		
32	БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	-	-
321	Үнэт цаас	-	-
32110	Төгрөг		
32120	Гадаад валют		
33	АВЛАГА	-	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага		
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага		
33300	Татаас, санхүүжилтийн авлага		
33400	Зээлийн хүүгийн авлага		
33401	Дансны авлага /ТӨҮГ/		
33402	Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/		
335	Бусад авлага	-	-
3351	Байгууллагаас авах авлага		
3352	Хувь хүмүүсээс авах авлага		
336	Зээлийн авлага	-	-
3361	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	-	-
33611	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөвт олгосон		
33612	Хувь хүмүүст олгосон зээл		
33613	Сургалтын төрийн сангийн зээлийн авлага		
33614	Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдэд олгосон зээл		
33615	Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгосон зээл		
3362	Гадаад зээлээс дамжуулан зээлдүүлсэн зээлийн авлага	-	-
33621	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөвт олгосон		
33622	Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдэд олгосон зээл		
33623	Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгосон зээл		
34	УРЬДЧИЛГАА	-	5,950,000.00

34100	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөвт олгосон		
34200	Төсөвт байгууллага		
34300	Тусгай зориулалтын сан		
34400	Төрийн өмчийн үйлдвэр, аж ахуйн газар		
34500	Хувийн хэвшлийн үйлдвэр, аж ахуйн газар		
34600	Урьдчилж гарсан зардал		5,950,000.00
3471	Урьдчилгаа тооцоо	-	-
34711	Бараа материал бэлтгэх урьдчилгаа		
34712	Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа		
34713	Цалингийн урьдчилгаа		
34714	Томилолтын урьдчилгаа		
35	БАРАА МАТЕРИАЛ	393,640,970.00	882,749,677.13
351	Түүхий эд материал	-	-
35110	Тусгай зориулалттай материал		
35130	Эм боох материал		
35200	Дуусаагүй үйлдвэрлэл		
35300	Бэлэн бүтээгдэхүүн	25,385,805.50	25,730,288.87
354	Хангамжийн материал	368,255,164.50	857,019,388.26
35410	Бичиг хэргийн материал	8,497,736.80	9,598,155.34
35420	Аж ахуйн материал	31,238,234.95	22,898,707.71
35430	Сэлбэг хэрэгсэл	25,201,822.97	24,299,575.51
35440	Түлш, шатах тослох материал		
35450	Барилгын засварын материал	1,116,400.00	3,971,701.60
35460	Хүнсний материал	32,831,121.14	40,443,143.25
35470	Бусад хангамжийн материал	269,369,848.64	755,808,104.85
35500	Биологийн хөрөнгө		
35600	Мал амьтад		
36	НӨӨЦИЙН БАРАА	-	-
36100	Барааны нөөц		
36200	Үрийн нөөц		
36300	Тэжээлийн нөөц		
36400	Шатахууны нөөц		
36500	Буудайн нөөц		
36600	Бусад нөөц		
36700	Бусад санхүүгийн хөрөнгө /ТӨҮГ/		
36800	Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/		
36900	Борлуулах зорилгоор эзэмшиж буй бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/		
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	33,449,878,013.09	32,446,363,298.39
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	-	-
371	Урт хугацаат хадгаламж	-	-
37110	Төгрөг		
37120	Гадаад валют		
372	Үнэт цаас	-	-
37210	Төгрөг		
37220	Гадаад валют		
373	Урт хугацаат зээл	-	-
3731	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	-	-
37311	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөвт олгосон		
37312	Хувь хүмүүст олгосон зээл		
37313	Сургалтын төрийн сангийн зээлийн авлага		
37314	Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдэд олгосон зээл		
37315	Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгосон зээл		
3732	Гадаад зээлээс дамжуулан зээлдүүлсэн зээлийн авлага	-	-
37321	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөвт олгосон		
37323	Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдэд олгосон зээл		
37324	Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгосон зээл		

37330	Урт хугацаат хөрөнгө оруулалт-зам, гүүр		
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	33,449,878,013.09	32,446,363,298.39
391	Газар		
392	Биет хөрөнгө	33,440,326,983.61	32,444,106,563.08
39201	Барилга, байгууламж, орон сууц	48,355,334,065.07	47,772,792,192.07
39202	Хуримтлагдсан элэгдэл	(16,272,446,224.72)	(17,014,645,583.83)
39203	Авто-тээврийн хэрэгсэл		
39204	Хуримтлагдсан элэгдэл		
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	760,955,535.61	945,837,829.61
39206	Хуримтлагдсан элэгдэл	(385,216,727.47)	(493,935,415.65)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	1,722,151,307.16	1,865,122,188.16
39208	Хуримтлагдсан элэгдэл	(1,331,269,103.52)	(1,410,831,675.83)
39209	Зам, гүүрийн байгууламж		
39210	Хуримтлагдсан элэгдэл		
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж		
39212	Хуримтлагдсан элэгдэл		
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	249,850,862.00	249,850,862.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	630,018,625.22	1,126,013,172.82
39215	Хуримтлагдсан элэгдэл	(289,051,355.74)	(596,097,006.27)
39216	Дуусаагүй барилга, байгууламж		
39217	Ном		
393	Биет бус хөрөнгө	9,551,029.48	2,256,735.31
39301	Програм хангамж	71,272,029.85	71,272,029.85
39302	Хуримтлагдсан элэгдэл	(61,721,000.37)	(69,015,294.54)
39303	Бусад биет бус хөрөнгө		
39304	Хуримтлагдсан элэгдэл		
394	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	-	-
39401	Биологийн хөрөнгө /ТӨҮГ/		
39402	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө /ТӨҮГ/		
39403	Хойшлогдсон татварын хөрөнгө /ТӨҮГ/		
39404	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө /ТӨҮГ/		
39405	Бусад эргэлтийн бус хөрөнгө /ТӨҮГ/		
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	33,847,465,280.57	33,335,062,975.52
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
411	Богино хугацаат үнэт цаас	-	-
4111	Төгрөг	-	-
41111	Бонд		
41112	Бусад үнэт цаас		
41113	Бондын хөнгөлөлт		
4112	Гадаад валют	-	-
41121	Бонд		
41122	Бусад үнэт цаас		
41123	Бондын хөнгөлөлт		
412	Богино хугацаат зээлийн өглөг	-	-
4121	Төгрөг	-	-
41211	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв		
41212	Хувь хүмүүст олгосон зээл		
41213	Сургалтын төрийн сангийн зээлийн өглөг		
41214	Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн зээл		
41215	Монгол банк		
41216	Арилжааны банк		
41217	Санхүүгийн бусад байгууллага		
4122	Гадаад валют	-	-
41221	Гадаадын Засгийн газар		
41222	Олон улсын байгууллага		
41223	Санхүүгийн зээл		

41224	Төслийн зээл		
41225	Бусад гадаад эх үүсвэрээс		
413	Өглөг	-	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг		
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг		
41330	Татаас, санхүүжилт, шилжүүлгийн өглөг		
41340	Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг		
41350	Зээлийн хүүгийн өглөг		
4136	Бусад өглөг	-	-
41361	Байгууллагад төлөх өглөг		
41362	Хувь хүмүүст төлөх өглөг		
41363	Татварын өглөг /ТӨҮГ/		
41364	НДШ - ийн өглөг /ТӨҮГ/		
41365	Ноогдол ашгийн өглөг /ТӨҮГ/		
41366	Дансны өглөг /ТӨҮГ/		
414	Урьдчилж орсон орлого	-	-
41410	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв		
41420	Төлбөртэй ажил үйлчилгээний урьдчилж орсон орлого		
41430	Барьцаа, дэнчингийн урьдчилж орсон орлого		
41440	Бусад урьдчилж орсон орлого		
41450	Төрийн өмчийн үйлдвэр, аж ахуйн газар		
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
421	Урт хугацаат үнэт цаас	-	-
4211	Төгрөг	-	-
42111	Бонд		
42112	Бусад үнэт цаас		
42113	Бондын хөнгөлөлт		
4212	Гадаад валют	-	-
42121	Бонд		
42122	Бусад үнэт цаас		
42123	Бондын хөнгөлөлт		
422	Урт хугацаат зээл	-	-
4221	Төгрөг	-	-
42211	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв		
42212	Хувь хүмүүсийн зээл		
42213	Сургалтын төрийн сангийн зээлийн өглөг		
42214	Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн зээл		
42215	Монгол банк		
42216	Арилжааны банк		
42217	Санхүүгийн бусад байгууллага		
4222	Гадаад валют	-	-
42221	Гадаадын засгийн газраас		
42222	Олон улсын санхүүгийн байгууллагаас		
42223	Санхүүгийн зээл		
42224	Төслийн зээл		
42225	Гадаадын арилжааны банк		
42226	Бусад гадаад эх үүсвэр		
42227	ОУВС-ийн зээл		
42228	Нөөц /өр төлбөр/ /ТӨҮГ/		
42229	Хойшлогдсон татварын өр /ТӨҮГ/		
42230	Бусад урт хугацаат өр төлбөр /ТӨҮГ/		
42231	Санхүүгийн бусад байгууллага /ТӨҮГ/		
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	33,847,465,280.57	33,335,062,975.52
51	Засгийн газрын хувь оролцоо	33,847,465,280.57	33,335,062,975.52
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	12,893,829,544.47	12,931,719,496.17
51101	Өмч: - төрийн	12,893,829,544.47	12,931,719,496.17

51102	- хувийн		
51103	- хувьцаат		
51104	Халаасны хувьцаа		
51105	Нэмж төлөгдсөн капитал		
51106	Эздийн өмчийн бусад хэсэг		
512	Хуримтлагдсан үр дүн	2,154,503,827.94	1,604,211,571.19
51210	Өмнөх үеийн үр дүн	2,154,503,827.94	2,154,503,827.94
51220	Тайлант үеийн үр дүн		(550,292,256.75)
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс		
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	18,799,131,908.16	18,799,131,908.16
51400	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
51500	Бодлогын өөрчлөлт алдааны залруулга		
51600	Нөөцийн сан		
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>33,847,465,280.57</u>	<u>33,335,062,975.52</u>

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	0.00	4,209,607,010.54
11	ТАТВАРЫН ОРЛОГО	0.00	-
110	Орлогын албан татвар	0.00	-
1100	Хувь хүний орлогын албан татвар	0.00	-
110001	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрх		
110002	Үйл ажиллагааны орлого		
110003	Хөрөнгийн орлого		
110004	Хөрөнгө борлуулсны орлого		
110005	Шинжлэх ухаан, утга зохиол, урлагын бүтээл тууривах, шинэ бүтээл, бүтээгдэхүүний болон ашигтай загвар зохион бүтээх, спортын тэмцээн, урлагийн тоглолт зохион байгуулах, тэдгээрт оролцож олсон орлого, тэргээртэй адилтгах бусад орлого		
110006	Урлагийн тоглолт, спортын тэмцээний шагнал, наадмын бай шагнал		
110007	Төлбөрт таавар, бооцоот тоглоом, эд мөнгөний хонжворт сугалааны орлого		
110008	Шууд бус орлого		
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0.00	-
110101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	0.00	-
